

“ОРОН НУТГИЙН ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАР,
ЭНТРЕПРЕНЕРШИП БОЛОВСРОЛ ОЛГОХ” ТӨСӨЛ (2019-2025)

ТӨСЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗӨВЛӨМЖ СТРАТЕГИ



ТӨСЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗӨВЛӨМЖ СТРАТЕГИ

Хүүхдийг Ивээх Сангаас (ХИС) Японы нийгмийн хөгжлийн сангийн санхүүжилт, Дэлхийн банкны менежментээр 2019-2025 онд “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөл хэрэгжүүлсэн. Тус төслийн зорилго нь өсвөр үеийн хүүхэд, залуучуудад хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох замаар сурлагын амжилтыг нь ахиулах, хөдөлмөр эрхлэлтэд бэлдэх юм.

Тус төслийн тогтвортой байдлыг хангах зөвлөмж стратеги нь төслийн хүрээнд туршин хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, санал санаачилга, хүрсэн үр дүнг боловсрол, хөдөлмөр эрхлэлт, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээрх үндэсний болон орон нутгийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулан түгээн дэлгэрүүлэх зөвлөмж арга зам, аргачлалыг олон талын оролцоонд тулгуурлан тодорхойлж, хамтрагч талуудад санал болгох зорилготой. Түүнчлэн энэхүү стратеги нь “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох төсөл”-ийн хүрээнд туршин хэрэгжүүлж, хүүхэд, залуучуудын хувь хүний ур чадварыг хөгжүүлэх боломжит арга зам гэдгийг нотолсон цогц арга хэмжээний үр дүнг нэгтгэн дүгнэж, зөвлөмжилсэн бичиг баримт юм. Стратеги нь тус төслийг хэрэгжүүлсэн байгууллага болох Хүүхдийг Ивээх Сангийн байр суурийг илэрхийлсэн болно.

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

1.1. Төслийн зорилт

Төслийн зорилгыг хангахын тулд дараах гурван зорилт дэвшүүлсэн:

- **Зорилт 1:** Орон нутгийн оролцоотой, хувь хүний үр чадвар болон энтрепренершипийн боловсрол олгох сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

Дэд зорилт 1.1: Орон нутгийн оролцоотой, хувь хүний үр чадвар болон энтрепренершипийн боловсрол олгох сургалтын хөтөлбөр боловсруулж, турших;

Дэд зорилт 1.2: Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх олон талт оролцогч бүхий хамтын ажиллагааг бий болгох;

- **Зорилт 2:** Хөтөлбөрийн хүрээнд сурсан мэдлэгээ бодитоор туршихад нь дэмжлэг үзүүлэн, өсвөр үеийнхний боловсруулсан бичил төслийг санхүүжүүлэх;
- **Зорилт 3:** Төслийн үр дүнтэй хэрэгжилт, тогтвортой байдлыг хангах орон нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, төслийн сайн туршлага, гарсан үр дүнг түгээн дэлгэрүүлэх.

Төсөл хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг шат шатанд, олон талын оролцоотойгоор тодорхойлсон. Төслийн үйл ажиллагаа нь үндэсний, аймгийн болон сумын түвшний хамтрагч талууд тухайлбал Төслийн удирдах зөвлөл, Төслийн Аймгийн Зөвлөл (ТАЗ), Төслийн Сумын Зөвлөл (ТСЗ) болон бусад оролцогч талуудын оролцоо, дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн.

1.2. Төслийн хамрах хүрээ, үр дүн

Монгол Улсын баруун, зүүн, төвийн болон хангайн бүсийн төлөөлөл болох:

- Ховд аймгийн Булган, Алтай,Үенч,Мөст,Манхан, Зэрэг сум,
- Завхан аймгийн Тэс, Баянтэс, Түдэвтэй, Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул сум
- Өвөрхангай аймгийн Богд, Гучин-Ус, Сант, Уянга, Бат-Өлзий, Хужирт, Хархорин сум
- Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь сум
- Сүхбаатар аймгийн Мөнххаан,Баяндэлгэр, Онгон, Эрдэнэцагаан нийт 29 сумын сургуулийн болон сургууль завсардсан, ажилгүйдэлд өртөх эрсдэлтэй 14-25 насны өсвөр үеийн хүүхэд, залуучуудыг төсөлд хамруулав.

Олон улсын чиг хандлага, Монгол хүүхдийн онцлогтой уялдсан, шинэлэг, төсөлд суурилсан сургалтын аргачлал бүхий “Энтрепренершипд суурилсан хувь хүний үр чадварыг хөгжүүлэх сургалт” (ESEL)-ын хөтөлбөрийг багц гарын авлага, хэрэглэгдэхүүний хамт боловсруулж, танхимын болон танхимын бүс сургалтын хэлбэрээр туршин хэрэгжүүлсэн. Тус сургалтын хөтөлбөр нь гадны хөтөлбөрийг шууд хуулбарлан авчраагүй, үндэсний зөвлөхүүд Монгол хүүхэд, залуусын онцлог, хэрэгцээнд тулгуурлан боловсруулсан гэдгээрээ онцлог юм. Түүнчлэн Монгол улсад төдийгүй олон улсад ихэвчлэн хоёр тусдаа заагддаг хувь хүний үр чадвар болон энтрепренершип боловсролыг нэгтгэснээрээ онцлогтой. Практик талаасаа хүүхэд залуучууд нэг баг болж орон нутагтаа эрэлт хэрэгцээтэй, тодорхой асуудлыг шийдсэн бичил төслүүд боловсруулж хэрэгжүүлэх явцдаа багаар ажиллах, цаг баримтлах, эрсдэл тооцох, санхүүгийн зохистой хуваарилалт хийх зэрэг үр чадваруудад суралцдаг. Суралцагчид бүгд энтрепренер болохгүй ч эдгээр мэдлэг, үр чадвар, сэтгэлгээ 21-р зуунд амжилттай ажиллаж, амьдрахад нэн хэрэгцээтэй юм. ESEL хөтөлбөр нь доорх үр чадвар, сэтгэлгээ, мэдлэгийг олгодог:

6 ҮНДСЭН УР ЧАДВАР:

1. Өөрийгөө ойлгох,
танин мэдэх

2. Нийгэм соёлын
орчлыг танин мэдэх

3. Бүтээлч байдал,
инноваци

4. Харилцах

5. Багаар ажиллах

6. Тунгаан бодох

2 СЭТГЭЛГЭЭ:

Өсөлтийн
сэтгэлгээ

Энтрепренершип
сэтгэлгээ

5 МЭДЛЭГ:

1. Энтрепренершипийн
суурь мэдлэг

2. Бизнес төлөвлөлт

3. Нөөцийн зохистой
хуваарилалт,
төлөвлөгөө
боловсруулж
хэрэгжүүлэх

4. Санхүүгийн мэдлэг

5. Дижитал мэдлэг

Уг сургалтыг чиглүүлэх 594 ESEL хөтөлбөрийн багш/зөвлөх, үүнээс багш бэлтгэх эрхтэй 50 Мастер багшийг бэлдэж, 5 аймгийн 29 сумын 35 Ерөнхий Боловсролын Сургууль, 25 Насан Туршийн Сургалтын нэгж (НТЧН), 6 МБС/Политехник коллежийн (ПК) 8773 хүүхэд, залуусыг (үүнээс 587 хүүхэд, залуусыг Хосолсон ESEL сургалтад) хамруулав. ESEL сургалт МБС-ийн сургалтын хөтөлбөрт заавал судлах хичээл болж оров. Зорилтот сургууль бүрд сурагчдын оролцоонд суурилсан Энтрепренер клуб үүсгэн байгуулж, үр шим хүртэгсдэд сургалтаар хөгжүүлсэн энтрепренершипийн мэдлэг, хувь хүний үр чадвар, сэтгэлгээгээ бататгах, хөгжүүлэх боломжоор хангасан.

ESEL сургалтын хөтөлбөрт хамрагдсан 3286 хүүхэд, залуус баг болон бичил төслийн шалгаруулалтад оролцож, тэдний 1471 нь шалгарч, санхүүгийн дэмжлэг аван 360 бичил төсөл хэрэгжүүлж, ESEL сургалтын хөтөлбөрийн хүрээнд эзэмшсэн мэдлэг ойлголт, үр чадвар, сэтгэлгээгээ бодитоор турших, хөгжүүлэх боломжоор хангагдсан. Зорилтот 6 сургууль, сургуульд суурилсан бизнесийн загварыг турших, сургуулийн үйл ажиллагааг дэмжих "Сургуульд суурилсан энтерпрайз" (ССЭ) санаачилгыг санхүүжүүлж, туршин хэрэгжүүлэв. Энтрепренершипийн боловсрол, хувь хүний үр чадварын хөгжлийг дэмжих, харилцан суралцах, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор туршлага судлах үйл ажиллагаануудыг бичил төсөл хэрэгжүүлэгч баг болон ССЭ-уудын хооронд бүсийн, аймгийн болон сумын хэмжээнд зохион байгуулав. Орон нутгийн түвшинд 5 бизнес көүч, 211 ментор, 224 үе тэнгийн ментор бэлтгэн чадавхжуулж, төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэв.

Төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх, тогтвортой байдлыг хангах зорилгоор төслийн хүрээнд бий болсон ТА3, ТС3 болон бусад оролцогч талуудыг төслөөр дамжуулан чадавхижуулж, дэмжлэгийн механизмыг бэхжүүлэн орон нутгийн оролцоо, хамтын ажиллагааг хөгжүүлэн, ESEL экосистем боловсруулан хэрэгжүүлэв. Төслийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, үр дүнг баталгаажсан арга хэрэгслээр үнэлж, үйл ажиллагааг сайжруулах арга хэрэгслийг бий болгож, төслийн үр өгөөжийг нэмэгдүүлсэн. Төслийн сайн туршлага, үр дүнг тогтмол түгээн дэлгэрүүлж, олон нийтийн дунд хувь хүний үр чадвар, энтрепренершипийн боловсролын ач холбогдлын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэв.

2. ТӨСЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН СТРАТЕГИ

2.1. Зорилго, ач холбогдол

Төслийн тогтвортой байдлын стратеги нь дараах ач холбогдолтой:

- a) Олон улсын хандлага, Монгол улсын онцлог, хүүхэд, залуучуудын эрэлт, хэрэгцээнд тулгуурлан боловсруулж, төслийн хүрээнд туршин хэрэгжүүлсэн, цаашид түгээн дэлгэрүүлэх боломжтой нь нотлогдсон хөтөлбөр, аргачлал, менежмент, зохион байгуулалт, санал санаачилга, үр дүнг нэгтгэн дүгнэх,
- b) Нэгтгэн дүгнэсэн үр дүнг үндэсний, орон нутгийн болон салбарын бодлого, үйл ажиллагаа, төсөв, зардлын хуваарилалттай уялдуулан нутагшуулах, түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох,
- c) Хүүхэд, залуучуудын өсөн дэвжих сэтгэлгээ, энтрепренер сэтгэлгээ, хувь хүний ур чадвар (нийгэм, сэтгэл хөдлөлийн ур чадвар), энтрепренершипийн суурь чадварыг хөгжүүлж, тэдний сурлагын амжилтыг нь сайжруулан, ирээдүйн хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх үйл ажиллагааны чиглэл болох,
- d) Хөгжлийн бодлого, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн нэг эх сурвалж болгон ашиглах. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад энэхүү төслөөр орон нутагт, сургуулиудад бий болсон оролцоонд суурилсан суралцахуй багшлахуйн арга техникийг туршлага болгох,
- e) Хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжихэд бүхий л түвшинд холбогдох оролцогч талуудын хамтын ажиллагааг хэрхэн хангах талаар менежментийн загвар гарсан бөгөөд үндэсний сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд уг загварыг ашиглах зэрэг болно.

2.2. Стратегийн онцлог, хэрэгжүүлэх зарчим

Төслийн тогтвортой байдлыг хангах зөвлөмж стратеги нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын бага ангиудаас эхлэн үндэсний сургалтын хөтөлбөр хэрэгжиж эхлэх цаг үетэй давхцаж буй, 2026 оныг боловсролын жил болгон Монгол улсын Засгийн Газраас зарлаж байгаатай уялдсан, багшийн хөгжлийн төвүүдийг орон нутагт түшиглэн хөгжүүлэх тогтолцооны шинжтэй шинэчлэл хийж эхэлж байгаатай уялдаж буйгаараа онцлог юм.

Стратегийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

- a) Орон нутаг, олон нийт, төр хувийн хэвшлийн оролцоо, түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлах,
- b) Үндэсний, бүс нутгийн, орон нутгийн болон салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах,
- c) Системийн онолын үүднээс иж бүрэн хандаж, стратегийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хэрэгжилтийг тэгш хангах,
- d) Байгаль орчин, нийгэмд ээлтэй байж, тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцүүлэх,
- e) Жендерийн тэгш байдал, тэгш хамран сургах,
- f) Сурагчийн хөгжих эрх ашгийг эн тэргүүнд тавих,
- g) Хөтөлбөрийн хэрэгжилтээр баталгаажсан үр дүнд тулгуурлах зэрэг болно.

Стратегийг дээр дурдсан зарчмыг баримтлан, төслийн тогтвортой байдлыг хангах үндсэн чиглэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг бүхэллэг байдлаар тэдгээрийг хөгжүүлэн боломж, эрсдлийг тооцон хэрэгжүүлнэ. Хэрэв бүрэлдэхүүн хэсгийг бүхлээр нь бүс зарим нэг бүрэлдэхүүнийг тусгайлан авч хэрэгжүүлэх нөхцөл байдал үүсвэл цаашдаа бусад бүрэлдэхүүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар төлөвлөлт хийж, цогц байдлаар хандахыг эрмэлзэнэ.

Төслийн хүрээнд боловсруулан, хөгжүүлсэн ESEL хөтөлбөрийн эко систем нь төслийн тогтвортой байдлын стратегийг хэрэгжүүлэх, төслийн тогтвортой байдлыг хангах үндсэн чиглэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан хамаарал, уялдааг хангах үйл ажиллагааны үе шатыг тэдгээрийн орц, бүтцийн элемент, оролцогч талуудын хамт дүрслэн харуулсан ерөнхий зураглал юм (Хавсралт 1). Төслийн тогтвортой байдлын стратегийг ESEL хөтөлбөрийн эко системд тодорхойлсны дагуу 1) Олон нийтийн ойлголт, оролцоо, 2) ESEL сургалт, 3) Тэтгэлэгт хөтөлбөр, 4) Менторинг, Көүчинг, 5) Үр дүн, сайн туршлага гэсэн үе шатаар, хавсралтад байгаа эх сурвалжуудыг аргазүйн гарын авлага, хэрэглэгдэхүүн болгон хэрэгжүүлнэ.

2.3. Оролцогч талуудын хамтын ажиллагаа

Стратегийг хэрэгжүүлэхдээ Боловсролын яамны манлайлал дор Боловсролын ерөнхий газар нь стратегийн үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэх тухай чиглэл, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар хангах, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд хөтөлбөрийн уялдааг хангахад тус тус хамтарч ажиллана. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд Боловсролын яамтай хамтран ажиллана. Аймгийн Боловсролын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар болон Насан туршийн боловсролын төв нь стратегийг орон нутагтаа хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангах, сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлж, зохион байгуулна. ЕБС, НТСН, МБС, ПК нь өөрийн онцлог, нөөцөд суурилан стратегийн бүрэлдэхүүн хэсгүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх, одоо байгаа хөтөлбөрүүдтэй уялдуулах, бусад оролцогч талуудтай хамтран ажиллахад гол үүрэг гүйцэтгэнэ.

3. ТӨСЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

3.1. ESEL сургалтын хөтөлбөр

3.1.1 Хэрэгжүүлсэн туршлага

ESEL сургалтын хөтөлбөрийг багшийн гарын авлага, суралцагчийн гарын авлага болон видео хичээлүүдийн хамт багцаар боловсруулж, таван жилийн хугацаанд орон нутгийн Ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн суралцахуйн нэгж, Мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежийн хүрээнд туршин хэрэгжүүлж, сургалтын багцыг гурав дахь удаагаа сайжруулж хэвлүүлсэн.

Төслийн хүрээнд дээр дурьдсан сургалтын байгууллагуудын 594 багш, сургалтын менежерийг ESEL-н багшаар бэлтгэж, чадавхжуулсан. Мөн БЕГ-тай хамтран сургууль, орон нутаг, үндэсний аль ч түвшинд ESEL хөтөлбөрийн багшийг сургах эрхтэй 50 Мастер багшийг бэлтгэн, ESEL-н багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлгийг байгуулан ажилласан. Түүнчлэн, Монгол улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн А-278 тоот тушаалаар ESEL сургалтын хөтөлбөр бүх МБС, ПК-ийн 3 жилийн сургалттай ангийн үндсэн хөтөлбөрийн нэг болсонтой холбогдуулан ESEL сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх ажлын хүрээнд, МБС-ийн багш нараас бүрдсэн Зөвлөх багийг байгуулж, чадваржуулж ажиллав. Ингэснээр, МБС-ийн ESEL-н багш нарыг тасралтгүй дэмжлэг, арга зүйгээр хангах, харилцан суралцах үйл явцыг дэмжих боломжийг бий болголоо.

Төслийн хүрээнд зорилтот сумдын ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангиудад нэмэлт хөтөлбөр байдлаар орсон. ESEL хөтөлбөрт холимог бүлгийн сурагчид нэг анги болж хичээллэсэн нь сурагчдад шинэлэг туршлага болсон. Мөн МБС, ПК-ийн ондоо мэргэжлийн суралцагчид нэг анги болж хичээллэсэн нь давуу тал болсон. ESEL-н бүх багш суралцагч нар Google classroom ашиглаж, үүний тулд google платформ дээр имэйл хаяг нээсэн нь цахим ур чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр болсон. Түүнчлэн хувь хүний ур чадварыг үнэлэх рубрик үнэлгээ, дижитал журнал нэвтрүүлсэн нь багш суралцагч бүрийг үнэлж ажигласны үндсэн дээр хувь хүний онцлогт тохируулан багт хуваарилах, тэдэнд тохирсон даалгавар өгөх зэрэг давуу тал бий болсон.

ESEL сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг суралцагч гар утас болон таблет ашиглан цаг хугацаа, орон зайнаас үл хамааран бие даан судлах боломжтой байхаар боловсруулсан. Энэ нь НТСН-н залуучуудад интернэтгүй орчинд ч хичээлээ судлан, тасралтгүй сурч хөгжих боломж олгосон.

Ерөнхийд нь дүгнэхэд ESEL хөтөлбөр нь: аливааг байгаагаас нь илүү сайжруулах, боломжийг илүү бүрдүүлэхэд хувь хүний ур чадварыг хөгжүүлэхийн чухлыг гаргаж тавьсан; хувь хүний ур чадварын хөгжил өөрийгөө болон бусдыг танихаас эхэлж, орчны хөгжилд өөрийн оролцоог гарган тавихтай уялдах нь оновчтой алхам болохыг тогтоосон; сургалтын уламжлалт аргыг богино хугацаанд өөрчилж болохыг тогтоосон; суралцагч бүрийн оролцоо нь тэдний хариуцлага тодорхой байх, үүргээ хүлээн зөвшөөрөхтэй уялдаатайг гарган тавьсан; сургалт нь зөвхөн багш суралцагч бус бусад оролцогч талуудын хамтын ажиллагаа болохыг сумын түвшинд гарган тавьсан; танхим болон танхимын бус үйл ажиллагааны үр дүнг цахимд суурилан хамтын хөгжил болгох боломжтой хувилбар болсон; төслийн үйл ажиллагааны үр дүнг үндэсний сургалтад нэвтрүүлж чадсан хувилбар болсон; хамтаараа суралцахуйн давуу талыг гарган тавьсан зэрэг болно.

3.1.2 Цаашид хэрэгжүүлэх арга зам

ЕБС-ийн түвшинд:

- Мастер багш нараас бүрдсэн үндэсний мэргэжлийн хөгжлийн бүлгийг чадваржуулж, онол арга зүйн удирдлагаар хангаснаар цаашдаа ESEL-н багш бэлтгэх, давтан бэлтгэх сургалтыг үр дүнтэй зохион байгуулах боломжтой.
- Аймаг, дүүрэг, сургуулийн түвшинд ESEL-н багшийн мэргэжлийн хөгжлийн бүлэг ажиллуулах нь багш нарт ажлын байран дээрээ тасралтгүй хөгжиж, бусад багш нартайгаа хамтран ажиллаж,

бие биеэсээ суралцах, арга зүйгээ сайжруулах боломжийг өгч, хөгжлийг дэмжих чухал арга зам болно.

- Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд ESEL сургалтын хөтөлбөрийг тусгаж, хэрэгжүүлэх. Ингэхдээ сурагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих болон хувь хүний хөгжлийг дэмжих, дэлхийн иргэн байх үр чадварыг хөгжүүлэх чиглэлтэй уялдуулах бүрэн боломжтой. Харин ESEL сургалтыг сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан багш нар заах эрхтэй нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх давуу тал болохыг анхаарна.
- ESEL сургалтын арга зүйг дунд болон ахлах ангийн сурагч бие даан судлаж болохоор боловсруулсан тул MEDLE.MN цахим сургуулийн платформд ESEL сургалтын багц болох дижитал гарын авлагууд, видео контент болон хичээлүүдийг байршуулж, интерактив хичээл хэлбэрээр бэлтгэн оруулах боломжтой.
- Бизнес судлалын судлагдахуунд ESEL-н сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглаж, сургалтын агуулгыг баяжуулах, нэгтгэн хэрэгжүүлэх боломжтой.
- Сонгон судлах хичээл хэлбэрээр ахлах ангийн хөтөлбөрт нэмж оруулах боломжтой. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 22.3-т заасны дагуу сонгон судлах хичээлийг холимог бүлгээр зохион байгуулж болохоор байгаа нь ESEL сургалтын арга зүй, зохион байгуулалттай бүрэн уялдаж байна.
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/26 дугаар тоот тушаалаар баталсан “Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөр”-т үндэслэн сургууль зохицуулах цаг дээр ESEL сургалтыг зохион байгуулах байдлаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах боломж байна. Дунд ангийн хувьд 66 цаг, ахлах ангийн 34 цаг байгаа бөгөөд хичээлийн цагт тооцож байгаа нь давуу талтай юм.
- Сургуулийн дотуур байранд сургалтын нэмэлт хөтөлбөрөөр хэрэгжих боломжтой.

Насан туршийн боловсролын түвшинд:

- Насан туршийн суралцахуйн нэгжүүдэд амьдрах ухааны болон боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой. Ингэхдээ, сургалтыг танхим ба цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулах нь НТЧН-ийн суралцагчид, сургуулиас гадуурх залуучуудын онцлогт тохиромжтой. Мөн сургалтыг зохион байгуулахдаа олон нийтийн дэмжлэгийг авах буюу сум, дүүрэг, багийн дарга, хорооны дарга, бусад холбогдох талуудтай хамтран ажиллах нь хүүхэд, залуучуудын оролцоонд суурилсан сургалтыг зохион байгуулахад дэмтэй.
- ESEL сургалтын хөтөлбөрийг жишиг хөтөлбөр байдлаар НТЧН-ийн онцлогт тохируулан хэрэгжүүлэхдээ холбогдох хичээлийн агуулгатай уялдуулж, баяжуулах бүрэн боломжтой. БЕГ-ын Насан туршийн боловсролын хэлтсийн удирдлага, зохион байгуулалттайгаар төсөл хэрэгжсэн аймгийн НТСТ болон ESEL-н багш нар зэргэлдээх аймаг, сум, дүүргийн НТЧН-үүдэд туршлагаа хуваалцан, үр дүнг түгээн дэлгэрүүлж ажилласан учир жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ойлголттой болсон.
- Зорилтот НТЧН-д төслийн хүрээнд сургалтын агуулга, арга зүйг насан туршийн суралцахуйн сургалтад үргэлжлүүлэн ашиглах нөөц (хүний болон тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн), тодорхой хэмжээгээр бүрдсэн тул уг нөөцийг ашиглах боломжтой.
- Насанд хүрэгчдийн түвшинд ESEL-ийг хэрэгжүүлэх менежмент, орон нутгийн иргэдийн хувь хүний үр чадварыг хөгжүүлэх сургалтад суурилсан загвар бий болсон тул аль ч аймаг, сумын насан туршийн сургалтын төвд хэрэгжүүлэх боломжтой.

МБС, ПК-ийн түвшинд:

ESEL сургалтын хөтөлбөрийг “ESEL чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар”-т шилжүүлэн боловсруулж, Мэргэжлийн боловсролын 3 жилийн сургалтад нэвтрүүлсэн. Үүний хүрээнд, сургалтын хөтөлбөр, багшийн болон суралцагчийн гарын авлагыг МБС-ийн онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж, ESEL хөтөлбөрөөр багшийг мэргэшүүлэх гурван үе шаттай сургалтыг цахим, танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, Мэргэжлийн боловсролын 130 багшийг бэлтгэв. ESEL хөтөлбөр 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн МБС-ийн 2-р ангид зориулсан 90 цагийн агуулгатай үндсэн хөтөлбөр хэлбэрээр хэрэгжиж байна.

3.2. Тэтгэлэгт хөтөлбөр - Бичил төсөл

3.2.1. Хэрэгжүүлсэн туршлага

ESEL хөтөлбөрөөр төгсөгчид сургалтаар эзэмшсэн хувь хүний ур чадвар, энтрепренер мэдлэг, ур чадвар, сэтгэлгээг төсөл хэрэгжүүлэх замаар хөгжүүлдэг. Төслийн туршид нийт 3286 хүүхэд залуучууд бичил төслийн тэтгэлэгт хөтөлбөрт бүртгүүлж, Пич уралдаанд оролцсоноос 1471 хүүхэд залуучуудын 360 баг санхүүжилт аван төслөө хэрэгжүүлсэн.

Бичил төсөл хэрэгжүүлсэнээр төсөлд суурилсан арга зүй нь хувь хүний болон энтрепренершип ур чадварыг хөгжүүлэхэд тохиромжтой арга зүй гэдгийг нотолсон. Хүүхэд залуучууд суман дээр байхгүй, өөрсдөд нь хэрэгцээтэй байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрсдөө санаачилж хэрэгжүүлэх ба орон нутагт тулгамдаж буй асуудлуудыг шийдэх боломжтойг харуулсан. Мөн орон нутагт энтрепренершип, менторын соёлыг түгээн дэлгэрүүлэх боломжтойг нотолсон. Суманд ажиллаж амьдарч буй төрийн албан хаагчид төслийн үйл ажиллагаанд ментор болж сайн дураар ажилсан нь тэднийг хүүхэд залуучуудын хамтаар тасралтгүй сурч хөгжих хүсэл эрмэлзэлтэй ба орон нутгийн хүүхэд залуучуудын хөгжилд гар бие оролцох сонирхолтойг харуулсан юм.

Бичил төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх алхмуудын хувьд эхний алхам нь ESEL хөтөлбөрийн сургалтын төгсгөлд 3-6 хүнтэй баг байгуулан орон нутаг, сургуульдаа тулгамдсан асуудлыг илрүүлж, түүнийг шийдэх арга замыг тодорхойлон энтрепренер санаагаа хөгжүүлэн бизнесийн төсөл боловсруулж, бичил төслийн тэтгэлэг олгох “Пич” уралдаант шалгаруулалтад оролцох юм. Багийн гишүүдийн тооны хувьд, ESEL хөтөлбөрийн гол зорилго нь бусадтай хамтарч төсөл хэрэгжүүлэнгээ хувь хүний ур чадвараа (багаар ажиллах, бусдын өмнө хариуцлага хүлээх, цагийн менежмент зэрэг) сайжруулах зорилготой тул ганцаараа бизнесийн санаагаа хэрэгжүүлэхийг дэмждэггүй. Уралдаант шалгаруулалтад нэг төгсөгч 3 хүртэлх удаа оролцох бөгөөд ингэхдээ баг болон бизнесийн санаагаа солих, эсвэл өмнөх оролцсон санаагаа улам хөгжүүлэн оролцох боломжтой.

Бичил төсөл санхүүжүүлэх тэтгэлэгт хөтөлбөрийн шалгаруулалт нь 3 үе шаттай. Энэ үе шатуудад ТС3-с эхлэн ТА3 хүртэл бүх шатны хамтрагч талууд оролцож ажилсан. Хүүхэд залуучууд бичил төслийн санаагаа цаасан дээр буулган бизнес төлөвлөгөө боловсруулахад аймгийн Бизнес Көүч зөвлөн тусалсан. Эхний шатанд ТС3 шалгаруулалт хийнэ. Ингэхдээ төслийн бичиг баримтын иж бүрдэл буюу ESEL төгссөн сертификат, бүртгэлийн маягт, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэхийг шалгана. Эдгээрийг үндэслэн хоёр дугаар шатны Пич уралдаанд төслөө танилцуулах боломжтой эсэхийг шийднэ. Хоёр дугаар шат нь Пич уралдаан бөгөөд уралдааныг Төслийн аймгийн зөвлөлөөс томилогдсон 3 хүний бүрэлдэхүүнтэй шүүгчдийн баг тухайн суманд ирж, олон нийтийн өмнө нээлттэйгээр зохион байгуулдаг. Шүүгч нар өгөгдсөн шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгнө. Гурав дугаар шатанд сумаас шалгарсан төслүүдийн шалгаруулалтыг ХИС-н шүүгчдийн баг мөн өгөгдсөн шалгуур үзүүлэлтийн дагуу шүүнэ. Эдгээр шатуудад сумын болон аймгийн зөвлөлийн гишүүд хүүхэд залуучуудын төслийг хэрхэн дүгнэж шалгаруулах талаар багагүй туршлага хуримтлуулсан.

Эцсийн шат буюу гурав дугаар шатанд шалгарсан багууд ХИС, сургууль болон ТС3 хамтарсан гурван талт гэрээ байгуулж эхний санхүүжилтээ авна. ТС3-ийн санхүү хариуцсан гишүүн, ТС3 даргын хамтаар банкинд дундын данс нээж, бичил төслүүдийн гүйлгээ, санхүүгийн тайланг хариуцна. Хэрэгжүүлэх явцдаа гурван удаагийн бичил төслийн үйл явцын болон санхүүгийн тайлан илгээнэ. Санхүүгийн тайланд үндэслэн санхүүжилтийг 65%, 25%, 10% гэж гурав хуваан олгодог. Бичил төслийн хэрэгжилтэд 6 сарын хугацаанд хяналт хийж, дэмжлэг үзүүлдэг. Сүүлийн тайлангаа хүлээлгэн өгснөөр цаашид бие даан хэрэгжүүлэх үйл явц эхэлнэ. Бичил төсөл хэрэгжүүлэх явцдаа хүүхэд залуучуудын баг тайлан бичиж байсан нь амьдрал дээр ажил хэрхэн явагддаг талаар төсөөлөлтэй болгосон юм.

Бичил төсөл хэрэгжүүлсэн багууд төгсөөд явахад төсөл хэрэгжүүлэх дараагийн үеэ сонгон өвлүүлэх эрхийг багийн гишүүд эдэлнэ. Шинэ баг төслийг хэрэгжүүлэхэд өмнөх төгсөгчид үе тэнгийн ментор болон үргэлжлүүлэн ажиллаж болно. Насан туршийн суралцахуйн нэгж дээр ESEL-ийн сургалтад хамрагдаж бичил төсөл хэрэгжүүлсэн баг төслөө гарааны бизнес болгон бие даан үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжтой.

Орон нутгийн байгууллага, бизнес эрхлэгч хувь хүмүүс, зөвлөх, менторууд хүүхэд залуучуудын багт бичил төслөө хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, нэмэлт санхүүжилт олгосон сайн туршлагууд бий болсон. Энэ нь орон нутгийн засаг захиргаа, хувь хүмүүс хүүхэд залуучуудын санал санаачилгыг хамтаараа дэмжих боломжтойг харуулсан.

3.2.2. Цаашид хэрэгжүүлэх арга зам

Пич уралдаанаас бусдад санаагаа ойлгуулах, олны өмнө илтгэх, танилцуулга бэлдэх, багаар ажиллах, бусдын өмнө хариуцлага хүлээх, утга төгөлдөр учир зүйтэй ярих зэрэг үр чадвар эзэмшдэг тул төсөл шалгаруулах, санхүүжилт босгох зорилгоос гадна энэ нь хүүхэд залуучуудын хувьд өөрийгээ таних, бусдад өөрийгөө таниулах суралцах үйл явц болдог. Тиймээс ESEL сургалтын дараа санхүүгийн тэтгэлэг олгож, бичил төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг заавал зохион байгуулах нь хүүхэд хөтөлбөрөөр сурч мэдсэн зүйлээ гүнзгийрүүлж, өөр талбар дээр суралцах, үр чадвараа хөгжүүлэхэд нэн чухал юм. Пич уралдаан зохион байгуулж, тэтгэлэг олгохдоо дээр дурдсан ХИС-ийн бичил төслийн журам болон шалгуур үзүүлэлтүүдийг ашиглах эсвэл өөрсдийн онцлогт тохируулан журам, шалгуур үзүүлэлт боловсруулж болно. Түүнчлэн бичил төслүүдийг зөвхөн мөнгөн санхүүжилтэд тулгуурлахгүй сургууль болон орон нутагт буй аливаа нөөцөд тулгуурлан хэрэгжүүлэх зэрэг өөр шийдлүүдийг эрэлхийлэх боломжтой.

Мөнгөн санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан зэргээс шийдвэрлэж болно. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тухайн дүүрэг, орон нутгийн хамтрагч талуудыг тодруулж, оролцоонд суурилан хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг энэ шаттай уялдуулбал дээр дурдсанчлан байгууллага, хувь хүмүүс, зөвлөх, менторууд дэмжих боломжтой.

3.3 Сургуульд суурилсан энтерпрайз (ССЭ)

3.3.1 Хэрэгжүүлсэн туршлага

ССЭ гэдэг нь сургуулийн удирдлага сурагчдын хамтаар сургуулийн орчинд энтрепренерийн үйл ажиллагаа явуулах буюу бизнес эрхлэх үйл ажиллагааг хэлнэ. ССЭ нь орон нутгийн түвшинд тодорхой зорилтот зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэхийг зорьж ажиллана. Харин ССЭ-г хэрэгжүүлэх, цаашлаад хөгжүүлэх зорилго нь хүүхэд залуучуудын энтрепренер сэтгэлгээ, бүтээлч чадварыг хөгжүүлэх, дэмжих, улмаар тэдэнд ажлын байранд гарах, хувиараа хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай үр чадварыг дэмжихтэй холбоотой.

Төслийн хүрээнд, төсөл хэрэгжүүлж буй 5 аймгийн эдийн засгийн нөхцөл байдлын үнэлгээ, төслийн 25 сумын зах зээлийн шинжилгээ хийж, ССЭ-г хэрэгжүүлэх хэрэгцээ, боломжийг тодорхойлох судалгааны тайлан боловсруулсан. Судалгааны явцад ССЭ-ийн олон улсын ойлголт хандлагыг тодорхойлж, Монгол улсад хэрэгжүүлэх боломжийг зах зээлийн орчноос гадна хууль эрхзүйн болон бодлогын талаас авч үзэн, сургалтын хөтөлбөрийн түвшинд судалж тодорхойлсон. Судалгааны явцад Монгол улсад хэрэгжүүлэх боломжтой ССЭ-ийн загварыг боловсруулан санал болгож, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлон, ССЭ-ийн жишээг хоёр чиглэлээр гаргасан.

Төсөлд хамрагдсан ЕБС-иудын хүрээнд ССЭ-ийн төслийн сонгон шалгаруулалтын уралдаан зарлаж, сонгогдсон зургаан сургуулиудад зориулсан чадавхжуулах сургалтууд зохион байгуулж, сургууль бүрийн төслийн онцлогт нь тохирсон тоног, төхөөрөмж хэрэглэгдэхүүнээр хөрөнгө оруулалт хийж, тодорхой чиглэлээр сайн туршлага бий болгон бусад ССЭ хэрэгжүүлж буй сургуулиуддаа хуваалцах арга хэмжээ хэрэгжүүлсэн юм. Эдгээр сургуулиудын ССЭ хэрэгжүүлж буй туршлагаа хуваалцах хоёр удаагийн семинарыг Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ЕБС, Өвөрхангай аймгийн Хархорин сумын ЕБС-ын 2-р сургууль дээр тус тус зохион байгуулав.

Түүнчлэн ССЭ алхамчилсан гарын авлага боловсруулж, ССЭ хэрэгжүүлж буй сургуулиуд ашиглаж эхэлсэн. 2024 оноос Завхан аймгийн Тэлмэн сумын сургууль Англи улсад төвтэй “Teach a man to fish” байгууллагаас зохион байгуулдаг Сургуулийн энтерпрайзын олон улсын уралдаанд оролцож, олон улсын туршлагаас суралцахын зэрэгцээ, зарим төрлөөр уралдааны ялагч болж, хөрөнгө босгох, шагнал авах болзол хангаад байна. Эдгээр сургуулиудын ССЭ-ийн үйл ажиллагаанд оролцох сурагч, багш, ажилтны оролцоо нэмэгдэж, үйл ажиллагаагаа сургалтын хөтөлбөртэйгээ уялдуулах, бодит асуудалд тулгуурласан сургалт зохион байгуулах боломжтой болж, өөрийн орлого нь нэмэгдэн сургуулийнхаа зорилгыг хэрэгжүүлэхэд зарцуулах, ССЭ-аа өргөтгөх боломжтой болж байна.

Зөвхөн сурагчдаар зогсохгүй сургууль тэр аяраа энтрепренер сэтгэлгээтэй болохын давуу талыг ССЭ туршлагауд харуулж чадсан. Сургууль өөрөө орлого олж түүнийгээ сургалтын орчин хангамжийг сайжруулсан сайн туршлагауд бий болсон. Мөн онол практикийг холбож, ССЭ үйл ажиллагааг олон судлагдахуунтай уялдуулж болохыг харуулсан.

3.3.2 Цаашид хэрэгжүүлэх арга зам

- ССЭ хэрэгжүүлэх гэж буй сургууль ССЭ гарын авлагын дагуу эхлээд зах зээлийн судалгаа хийх ба ССЭ нь орлого олох боломжтойн дээр сургалтын хөтөлбөртэй уялдуулах, сурагчдын хувь хүний үр чадвар энтрепренер сэтгэлгээг хөгжүүлэх ач холбогдолтой гэж үзвэл сургуулийн баг хамт олны зорилт болгон ССЭ-д ажиллах албан тушаалтнуудыг тодорхойлох боломжтой. Эс бөгөөс хэрэгжүүлэх явцад сургуулийн хамт олны оролцоо дэмжлэг туслалцаа сул байх магадлалтай нь өмнөх ССЭ жишээнээс харагдсан. ССЭ нь сургуулийн нийт багш, ажилтан суралцагчдын ойлголцол, оролцоо, хамтын хүчин чармайлтаар үр дүнд хүрэх юм.
- Сургуулийнхаа алсын хараа, зорилгод ССЭ хөгжүүлэх талаар тусгах нь тогтвортой үйл ажиллагаа явуулах нэг тулгуур бөгөөд сургуулийн түвшинд ССЭ хэрэгжүүлэх боломжтой.
- ССЭ байгуулж хэрэгжүүлэхдээ нэмэлт ажлын байр бий болгохгүй байхыг эрмэлзэх бөгөөд сургуулийн үндсэн бүтэц, зохион байгуулалт, багш, ажилтны чиг үүрэгтэй уялдуулан хэрэгжүүлнэ. Ингэснээр ССЭ нь сургуулийн үндсэн үйл ажиллагааны салшгүй хэсэг байж, сургуулийн зорилгыг хэрэгжүүлэх нэг хөшүүрэг болно.
- ЕБС-ын хувьд санхүүжилтийн эх үүсвэр босгохын тулд сургуулийнхаа төгсөгчдөд хандах боломжтой. Дараагийн боломжит хандивлагчид нь тухайн сумын нутгийн зөвлөл байж болно. Учир нь нутгийн зөвлөлд гол төлөв тухайн орон нутгаас төрөн гарсан амжилттай бизнес эрхлэгчид, нэр нөлөө бүхий хүмүүс багтдаг. Энэ мэтчилэн боломжит хандивлагчдыг тодорхойлсны дараа тэдэнтэй хэрхэн холбоо тогтоох, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг хэрхэн хүргэх, тэднийг хандив, хөрөнгө оруулахад ямар арга замаар сэдэлжүүлэх гэх зэрэг болон бусад үйл ажиллагаануудыг тодорхойлох шаардлага тулгарна. Хандивлагчидтай холбоо тогтоох, тэднийг сэдэлжүүлэх, мэдээлэл өгөх олон төрлийн арга зам байж болох ч хамгийн хялбар, зардал багатай үр ашигтай арга зам нь интернэт, цахим орчныг ашиглах явдал гэж үзлээ. Цахим орчныг ашиглах тухайд сургуулийн албан ёсны вэбсайт нээн ажиллуулж болох ч энэ нь цаг хугацаа, зардал их шаардах тул Facebook хуудас нээн ажиллуулах нь илүү тохиромжтой болов уу. Сургуулийн Facebook хуудсыг хандивлагчидтай холбоо тогтоох, тэднийг сэдэлжүүлэх, мэдээ, мэдээллээр хангахад ашиглах юм.
- Сургууль нэмэлт хөрөнгө оруулалтгүйгээр ССЭ хэрэгжүүлэх боломжтой. Үүний тулд бэлэн байгаа нөөцүүдээ тооцож, тэдгээрийг ашиглан ямар үйл ажиллагаа эрхлэх боломжтой болохоо тодорхойлох нь боломжтой.

МУ-ын Боловсролын ерөнхий хуулийн 37-р зүйлийн 37.6-т “Сургалтын байгууллага нь сургууль хөгжүүлэх сантай байж болох бөгөөд сангийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасан байдаг. Иймд нэг талаас зорилго, зориулалтад нийцэж байгаа, нөгөө талаас сургуулийн төсвийн данснаас тусад нь хөтлөх оновчтой гэдэг үндэслэлээр ССЭ-г үүсгэн байгуулахад шаардлагатай хөрөнгийг босгох, цаашилбал, ССЭ-гийн үйл ажиллагаанаас олсон орлого, ашгийг Сургууль хөгжүүлэх санд төвлөрүүлж, зарцуулж, тайлагнах нь боломжтой.

- ССЭ-ийн орлогынхоо нэг хэсгийн ССЭ-аа хөгжүүлэх, өргөтгөх, үйл ажиллагааг нь тасралтгүй явуулах боломжийг хангахад, тодорхой нэг хэсгийг энэ үйл ажиллагаанд оролцогч талуудыг урамшуулах, бас тодорхой хэсгийг сургуулийнхаа үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад санхүүжилт шаардлага байгаа үйл ажиллагаанд зарцуулж болно.
- Сургуулийн менежментийг хөгжүүлэх зорилтын хүрээнд сургуулийн менежментийн гурван давхаргат пирамидын загвартай уялдуулан сургуульд суурилсан сургуулийн хөтөлбөртэй, суралцахуйгаа өөрөө удиран хөгжигч сурагчтай, өөрчлөгдөн хөгжигч багштай, суралцахуйн зангилаа талбар болсон сургууль болон хөгжих суурь нь ССЭ байх боломжтой.

3.4 Энтрепренер клуб

3.4.1 Хэрэгжүүлсэн туршлага

Суралцагчдын ESEL сургалтын явцад эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэлгээг бататгах; сурснаа бусадтай хуваалцах боломжийг олгох, сургуулийн төдийгүй орон нутгийн түвшинд тулгамдсан асуудлуудыг тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах боломж олгох нэг арга зам нь сургууль, НТСН, МБС-д суурилсан Энтрепренер клуб ажиллуулах юм. Төслийн хүрээнд нийт 45 клуб байгуулагдаж, 2940 хүүхэд залуучууд элссэн. Энэ хугацаанд шилдэг клуб шалгаруулах хоёр удаагийн аян өрнүүлж хүүхэд залуучуудыг идэвхжүүлсэн.

3.4.2 Цаашид хэрэгжүүлэх арга зам

Энтрепренер клубийг хүүхэд, залуучуудын сайн дурын оролцоонд тулгуурлан зохион байгуулж, клубийн дүрэм, үйл ажиллагааны чиглэлээ бүх гишүүдийн оролцоотойгоор хүүхдүүд өөрсдөө тодорхойлдог учир клубийн бүтэц зохион байгуулалт, суралцагчдын оролцоог хангахад төдийлөн бэрхшээл тохиолдохгүй. Хүүхдийн оролцооны явцад хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг эн тэргүүнд тавьж, зохион байгуулах, болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, хариу арга хэмжээний төлөвлөгөө бэлэн байх ба хүүхэдтэй ажиллах, хамтрах багш бусад хүмүүс хүүхдийн оролцоонд хүүхдийн аюулгүй байдлыг хангах ёс зүйн дүрэмтэй танилцаж, гарын үсэг зурсан байх шаардлагатай. Ингэснээр хүүхдийн оролцоотой холбоотой гарах эрсдэлийг үнэлж, бууруулах арга хэмжээ авах боломж бүрдэнэ.

Аймгийн Боловсролын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар болон Насан туршийн боловсролын төв нь Энтрепренер клубийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, клубийн үйл ажиллагааны арга аргачлал, сайн туршлагаудыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах боломжтой. Ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн суралцахуйн төв, Мэргэжлийн боловсролын сургуулиуд Энтрепренер клубийн үйл ажиллагаа, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэн ажиллах багш, ажилтнуудын оролцоог хангах, клубийг олон нийтрүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулахад удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр дэмжин ажиллах шаардлагатай.

Энтрепренер клубийг байгуулах зөвлөмж:

- **Бүтэц, зохион байгуулалт:** Энтрепренер клубийг удирдлагын баг, клубийн ахлагч болон клубийн гишүүд гэсэн бүтэцтэй байхаар зохион байгуулах
- **Чиглүүлэгч багшийн дэмжлэг:** Энтрепренер клубийг эрхэм зорилго, бүтэц зохион байгуулалт, гишүүнчлэл, дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө гаргах, клубийн өөрийн үнэлгээг хийхэд болон үйл ажиллагааг тогтмолжуулахад анхаарч ажиллах
- **Сургуулийн захиргааны дэмжлэг:** Клубийн уулзалт, арга хэмжээг зохион байгуулах хүүхдэд ээлтэй танхимаар хангах болон олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулахад удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр дэмжин ажиллах
- **Төсөлт үйл ажиллагаа:** Сургууль, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах төсөлт ажил болон үйл ажиллагаа санаачлах, төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах боломжоор хангах
- **Хамтын ажиллагааг дэмжих:** Хүүхэд, залуучууд орон нутгийнхаа хэрэгцээг олж харах, эргэн тойрны асуудлаа шийдвэрлэхийн тулд бусад хүмүүстэй-энтрепренерүүд болон байгууллагуудтай хамтран ажиллах гарцыг нээж өгөх
- **Эргэн дүгнэх уулзалтууд:** Энтрепренер клубийн ахлагчдын/удирдлагын багийн/гишүүдийн дунд эргэн дүгнэх уулзалт болон туршлага судлах үйл ажиллагааг цахимаар болон биечлэн зохион байгуулах
- **Технологи ашиглах:** Суралцах, хамтын ажиллагааг хөнгөвчлөхийн тулд онлайн нөөц, хэрэгслийг ашиглах. Жишээлбэл: Энтрепренер клубийн гишүүдийн хурлыг цахимаар зохион байгуулах, клубийн цахим хуудас хөгжүүлэх гэх мэт. Ингэснээр, сургууль орон нутагт тогтвортой үйл ажиллагаатай Энтрепренер клубийг үүсгэн байгуулах боломж бүрдэнэ.

3.5 Оролцогч талуудын оролцоо, түншлэл

3.5.1 Хэрэгжүүлсэн туршлага

Төслийн хүрээнд зорилтот аймаг, сумдад төр, хувийн хэвшил, олон нийтийн төлөөллийг дайчлан олон талт дэмжлэгийн механизмыг бий болгосон ба төслийн үйл ажиллагаануудаар дамжуулан оролцогч талуудыг чадавхжуулж, орон нутгийн түвшин дэх утга учиртай, бодит оролцоо, хамтын ажиллагааг дэмжин хангах замаар төслийг үр дүнтэй хэрэгжүүлсэн.

Төсөл хэрэгжиж эхлэх үед аймаг тус бүрийн удирдлагатай төслийн хэрэгжилтийн хүрээнд хамтран ажиллахаар харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Түүнчлэн 5 аймаг, 25 сум тус бүрд олон талт төлөөлөл бүхий Төслийн аймгийн зөвлөл (ТАЗ) болон Төслийн сумын зөвлөлийг (ТСЗ) байгуулахын зэрэгцээ зорилтот сумдын 35 сургууль, 25 НТХН, 6 МБС-д ЕСЕЛ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх чиглүүлэгч болон мастер багш нар, үе тэнгийн менторуудыг бэлтгэсэн. Мөн тэтгэлэгт бичил төсөл болон ССЭ санаачилгын хүрээнд зорилтот хүүхэд, залуус, багш нар, сургуулиудын

чадавхыг бэхжүүлж, эдгээр үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Бизнес көүч, ментор бүхий сургуулийн болон орон нутгийн түвшний механизмыг бий болгосон.Тухайлбал ТСЗ-ийн хяналт, үнэлгээ хариуцсан гишүүн болон менторууд нь бичил төсөл хэрэгжүүлж буй багуудад дэмжлэг үзүүлэх, Бизнес көүчүүд ССЭ хэрэгжүүлэгч сургуулиудад мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүргийг гүйцэтгэх явцдаа чадавхжиж, хоорондоо уялдаа холбоотой ажиллаж, хамтын ажиллагаагаа бэхжүүлсэн. Эдгээр туршлага нь төслийн үр дүнгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх төдийгүй төслийн бус нутаг дэвсгэрт төслийн үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд жишиг туршлага болох юм.

Төслийн тогтвортой байдлыг хангах, үр дүнг үргэлжлүүлэх, нутагшуулах, түгээн дэлгэрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх орон нутгийн дэмжлэгийн механизмыг бүрдүүлэгч оролцогч талуудыг дөрвөн түвшинд авч үзнэ:

- a) Олон нийт (Иргэний нийгмийн байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сайн дурын идэвхтэн гишүүд),
- b) Хувийн хэвшил (Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Бизнесийн холбоод, бизнес эрхлэгчид)
- c) Төрийн байгууллага (Аймаг, сумдын засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, холбогдох газар /Боловсролын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар (Жижиг дүнд үйлдвэрлэл чиглэл), Нийгмийн бодлогын хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс гэх мэт/
- d) Боловсролын байгууллага (Боловсролын газар, ЕБС, НТБГ, МБС)

Дэмжлэгийн механизм нь боловсролын байгууллагын оролцогч талуудын бүтцэд түшиглэн төрийн байгууллага, хувийн хэвшил, олон нийтийн шууд оролцоотойгоор, талуудын харилцаа холбоо, хамтын ажиллагаа дээр суурилан хэрэгжинэ.

3.5.2 Цаашид хэрэгжүүлэх арга зам

Төслийн үр дүнг нутагшуулах, түгээн дэлгэрүүлэхэд орон нутгийн холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын ажиллагааны механизмыг цогцоор бий болгох нь төслийн аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Үүний тулд дээр дурдсан олон талт оролцоо бүхий бүтцэд суурилсан хамтын ажиллагааг дэмжиж, системийн аргаар төслийн үр дүнгийн тогтвортой байдлыг хангах стратегийг хэрэгжүүлнэ.

Төслийн тогтвортой байдлыг хангах стратеги нь төслийн үр дүнг холбогдох чиг үүрэгт нэмэлт ажил үүрэг бус тухайн бүтцийн чиг үүргийн нэг хэсэг хэмээн үзэх зарчмыг баримтлах ба орон нутгийн механизм, түүнийг бүрдүүлэх оролцогч талуудыг тодорхойлохдоо тухайн орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй одоогийн буюу аль хэдийн бий болсон бүтцийг дайчилж, тэдний оролцоо, хамтын ажиллагаанд түшиглэнэ. Тухайлбал, ХИС-ийн төслийн хүрээнд байгуулагдсан ТАЗ, ТСЗ-ийн туршлагыг тухайн аймаг, сум, сургуулийн түвшинд тодорхой чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж буй албан ба албан бус бүтцүүд, жишээлбэл сургуулийн зөвлөл, Иргэний нийгмийн байгууллага, холбоод, Нутгийн зөвлөл, Эцэг эхийн зөвлөл, Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөл, Аймаг, сумын хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрх, хөгжил, хамгаалал оролцооны байгууллагуудын сүлжээ зэргийг түшиглэн байгуулах боломжтой. Орон нутгийн механизмын үр дүнтэй хэрэгжилтийг хангахын тулд төслийн хүрээнд боловсруулагдсан ТАЗ, ТСЗ-ийн жишиг журмыг (Хавсралт 5) эх сурвалж болгон ашиглаж, механизмыг бүрдүүлж буй оролцогч талуудад чиглэсэн мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, чадавх бэхжүүлэх, арга зүйн дэмжлэгийн үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлнэ.


4. ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ЭНТРЕПРЕНЕРШИПД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ:

- a) Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд суралцагчийн эзэмших чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн туршилтад суурилсан (төсөлт ажил) сургалтын болон хичээл, сургалтаас гадуурх үйл ажиллагааны агуулга, аргачлал, зохион байгуулалт бий болгон хэрэгжүүлэх,
- b) Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд багш бэлтгэх, давтан бэлтгэх сургалт, үйл ажиллагаанд суралцагчийн чадамж, нийгэм, сэтгэл хөдлөлийн ур чадварыг хөгжүүлэх агуулга тусгаж, багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих зардлаар санхүүжүүлэн хэрэгжүүлэх,
- c) Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааны хувьсах зардалд суралцагч баг болон тухайн орон нутаг, сургуулийн хэмжээнд тулгамдсан асуудлыг танин мэдэж, түүний шийдлийг санал болгон, төсөлт ажил хэрэгжүүлэх, энэ зорилгоор сурсан мэдсэн зүйлээ бодит амьдралд ашиглах байдлаар ерөнхий чадамж, сэтгэлгээ, нийгэм сэтгэл хөдлөлийн ур чадвараа хөгжүүлэх боломжтой зардал тусгаж хэрэгжүүлэх,
- d) Боловсролын ерөнхий хуулийн 37.4 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд боловсрол сургалтын байгууллага “Сургуульд суурилсан энтерпрайз” хөгжүүлэх байдлаар суралцагч сургалтаар олж авсан мэдлэг, ур чадвараа бодит асуудал шийдвэрлэхэд хэрэглэх замаар хөгжих, боловсрол сургалтын байгууллага өөрийн орлого олж, байгууллагынхаа зорилгыг хэрэгжүүлэхэд ашиглах боломжийг бий болгон, сургууль хөгжүүлэх санг энэ зорилгоор өргөтгөн хөгжүүлэх,
- e) Хүүхэд залуучуудад мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрт бэлтгэх, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагчид, Мэргэжлийн боловсролын сургуулийн суралцагчид, Насан туршийн суралцахуйн нэгжийн суралцагчдын энтерпренер санал, санаачилгыг дэмжих хөтөлбөр бий болгон хэрэгжүүлэх,
- f) Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөтгөн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хүүхэд залуучуудын сэтгэлгээ, зөөлөн ур чадварыг хөгжүүлэх бодит асуудалд тулгуурласан сургалт, хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх.

5. ТӨСЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД АШИГЛАХ ЭХ СУРВАЛЖ, МАТЕРИАЛУУД

Хавсралт 1


ЕSEL ХӨТӨЛБӨРИЙН ЭКО СИСТЕМ



ESEL ХӨТӨЛБӨРИЙН СУРАЛЦАХУЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ ЭКСПАНСИВ СУРАЛЦАХУЙН ОНОЛ



ХОСОЛСОН ESEL ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



ESEL ХӨТӨЛБӨРИЙН ГАРЫН АВЛАГУУД ТАТАХ ЛИНК

https://savethechildren.mn/?page_id=9830&lang=mn



ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР БОЛОН ТӨСЛИЙН АЙМГИЙН ЗӨВЛӨЛ, ТӨСЛИЙН СУМЫН ЗӨВЛӨЛИЙН ЖУРАМ

1. Тэтгэлэгт хөтөлбөрийн байгаль орчин нийгэм эрүүл мэндийн үнэлгээний хуудас
2. Пич уралдааны шүүгчдийн үнэлгээ өгөх шалгуур, онооны хүснэгт
3. Тэтгэлэгт шалгарсан багуудтай хийх гэрээ
4. Бичил төсөл хэрэгжүүлэхээр санхүүжилт авсан буюу тэтгэлэгт хөтөлбөрт тэнцсэн багуудын тайлангийн маягт
5. Төслийн аймаг болон сумын зөвлөлийн журам



Эдгээр хавсралтуудыг дээрх QR кодыг уншуулан татаж авна уу



Save the Children

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
☎ +976-11-329365, +976-11-329371
📠 +976-11-329361

✉ mongolia.secretary@savethechildren.org
🌐 www.savethechildren.mn
📘 Save the Children in Mongolia
🐦 Save the Children MN